



**ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
АЛБАН ДААЛГАВАР**

2021 оны 03 сарын 22 өдөр

Дугаар 01

Ховд

**Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх,  
түймэртэй тэмцэх зарим арга хэмжээний тухай**

Жил бүрийн хавар, намрын хуурайшилтын улиралд ой, хээрийн гал түймрийн нөхцөл байдал хүндэрч аймаг, орон нутгийн эдийн засагт ихээхэн хэмжээний хохирол учруулсаар байна.

Улсын хэмжээнд 2020 онд Улаанбаатар хот, Архангай, Баянхонгор, Булган, Говьсүмбэр, Дорнод, Завхан, Өвөрхангай, Сэлэнгэ, Сүхбаатар, Төв, Увс, Ховд, Хөвсгөл, Хэнтий зэрэг 15 аймгийн 74 суманд нийт 142 удаагийн ой, хээрийн гал түймэр гарч, 245.311 мянган га талбай түймэрт өртөж, экологийн хохирол 3 тэрбум, эд материал 41.1 сая, түймрийг унтраахад 145.4 сая төгрөг зарцуулж, нийт 3.2 тэрбум төгрөгийн хохирол учирсан байна.


Аймгийн хэмжээнд 2020 онд Булган суманд 1, Үенч суманд 1 нийт 2 удаагийн хээрийн гал түймэр гарч 0.5 га талбай түймэрт өртөж, байгаль экологид 654240 мянган төгрөг, түймрийг унтраахад 0.5 сая төгрөгийн зардал нийт 1.1 сая төгрөгийн хохирол учирч 61 хүн, 4 автомашин техник хэрэгсэлтэй ажилласан.

Цаг уур, орчны шинжилгээний газраас ирүүлсэн цаг агаарын урьдчилан сэргийлэх мэдээллээр 2021 оны 3, 4 дүгээр сард агаарын температур Алтай, Хангай, Хөвсгөл, Хэнтийн уулархаг нутаг, Дорнод Монголын тал нутгаар олон жилийн дунджаас 1-1.5 градусаар илүү дулаан, 3, 4 дүгээр саруудад олон жилийн дунджаас бага хур тунадастай, нийт нутгаар хуурайшилтын зэрэг өндөр байх мэдээлэл ирүүлсэн.

Иймд 2021 оны Хөдөлмөрийн тухай хуулийн 74 дүгээр зүйлийн 74.2.2, Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын менежмент, Covid-19 цар тахлын үед аюулгүй ажиллах ерөнхий шаардлага, MNS ISO/PAS 45005:2021 стандарт, мэргэжлийн байгууллагаас гаргасан халдвар хамгааллын дэглэмийг мөрдөж Улсын Онцгой комиссын 2021 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн "Ой, хээрийн

2021 AD/01 Ch

02 0001



Scanned with

MOBILE SCANNER

## 2.

гал түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх зарим арга хэмжээний тухай” 02 дугаар албан даалгаврыг хэрэгжүүлэх, ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх, ажлын чанар, үр дүнг дээшлүүлэх зорилгоор ДААЛГАХ нь:

Нэг: Баруун бүсийн төв-Ховд аймгийн Онцгой байдлын газар  
/хурандаа Б.Алтанбадралт/-д

1.1. Ойн тухай хуулийн 17, 18, 26 дугаар зүйлд заасны дагуу ой, хээрийн гал түймрээс хамгаалах, түймэртэй тэмцэх төлөвлөгөө, төсвийг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргаар батлуулж, хэрэгжилтийг хангах.

1.2. Галын аюулгүй байдлын тухай хуулийн 10 дугаар зүйл, 10.2.4, 10.3, дугаар зүйлд заасны дагуу орон нутагт байгуулагдсан “Гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсэг”-т тодотгол хийх, гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээгээр эрсдэл ихтэй үнэлэгдсэн сум, багт нэмэлт хэсэг байгуулах.

1.3. Гамшгаас хамгаалах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.19, Ойн тухай хуулийн 15 дугаар зүйлд заасны дагуу ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, түймэртэй тэмцэх, унтраах сургалт, дадлагыг зохион байгуулах.

1.4. Хөдөлмөрийн тухай хуулийн 74 дүгээр зүйлийн 74.2.2, Коронавируст халдвар (Covid-19)-ын цар тахлын тархалттай холбогдуулан мэргэжлийн байгууллагаас гаргасан халдвар хамгааллын дэглэмийг мөрдлөг болгон хүн хүч, техник хэрэгслийг дайчилж ой, хээрийн гал түймэр гарсан тохиолдолд тухай бүр шуурхай унтраах арга хэмжээг зохион байгуулах.

1.5. Монгол Улсын Шадар сайдын 2019 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн 51 дүгээр тушаалаар батлагдсан “Онцгой байдлын байгууллагын бүсийн төвийн ажиллах журам”-ын 4 дүгээр зүйлийг хэрэгжүүлэн бүсийн хэмжээнд ой, хээрийн гал түймэртэй тэмцэх албаны бэлтгэл бэлэн байдлыг хангуулах, ой, хээрийн гал түймэр унтраах үйл ажиллагаанд харьяа Онцгой байдлын газруудыг нэгдсэн удирдлагаар хангах, хүч хэрэгслийг дайчлан гаргах.

1.6. Коронавируст халдвар (Covid-19)-ын цар тахалтай холбогдуулан мэргэжлийн байгууллагаас гаргасан халдвар хамгааллын дэглэмийг мөрдөж ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, унтраах үйл ажиллагааг төлөвлөх, сургалт сурталчилгаа явуулах, дадлага сургалтыг аймаг, орон нутгийн төрийн болон төрийн бус байгууллага, хуулийн этгээд, иргэдийн оролцоотой хамтран танхимаар болон цахимаар зохион байгуулах.

## 3.

1.7. Онцгой байдлын байгууллагын "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм"-ийн 5 дугаар бүлгийн 3.3, 3.5-т заасныг хэрэгжүүлэн төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын алба хаагчдыг эрүүл мэндийн үзлэгээр оруулж, хачигт халдвараас урьдчилан сэргийлэх, дархлаажуулах тарилгад хамруулах.

1.8. Нисгэгчгүй нислэг төхөөрөмжийг ашиглах дадлага сургалтыг зохион байгуулаж, ой, хээрийн гал түймэр унтраах үйл ажиллагаанд тогтмол ашиглах.

1.9. Ой, хээрийн гал түймрийн эрсдэл бүхий бүс нутагт үйл ажиллагаа явуулж байгаа амралтын газар, аялал жуулчлалын бааз зэрэг үйлчилгээний байгууллагуудад төлөвлөгөөт бус гал түймрийн улсын хяналтын шалгалтыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулах, ой хээрийн гал түймэр унтраах анхан шатны багаж хэрэгслийн нөөц бүрдүүлэх, бэлэн байдлыг хангуулах.

1.10. Ой, хээрийн гал түймэр унтраах томилгоот бүрэлдэхүүн, дайчлагдан ажиллах иргэдийн хувийн бэлтгэл, бэлэн байдлыг хангах, автомашин, техник тоног төхөөрөмж, бүх төрлийн багаж хэрэгслийн засвар үйлчилгээг хийж, аюулгүй найдвартай ажиллагааг хангах, шаардлагатай сэлбэг, хэрэгслийн нөөцийг бүрдүүлэх.

1.11. Ой, хээрийн гал түймрийн голомтод ажиллах 1 бүлгийг 12 хүний бүрэлдэхүүнтэй томилгоожуулж офицероор ахлуулж, үүрэг гүйцэтгэх бие бүрэлдэхүүнийг байршил тодорхойлогч /GPS/, сансрын холбооны утас /IRIDIUM/ болон байр зүйн зургаар хангах.

1.12. Хавар, намрын хуурайшилтын улирал, зуны хэт халалтын үед иргэд олон нийтэд ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, унтраах чиглэлээр сэрэмжлүүлэг, сурталчилгаа нэвтрүүлэх ажлыг орон нутгийн телевиз, хэвлэл мэдээлэл, цахим орчныг ашиглан ард иргэдэд хүргэх ажлыг зохион байгуулах.

Хоёр: Цагдаагийн газар / Цагдаагийн хурандаа Э.Даваасүрэн /-д

2.1. Ой, хээрийн гал түймрийн дуудлагаар ажиллахаар томилогдсон цагдаагийн байгууллагын алба хаагч нь хэргийн газрын үзлэгийг удирдан зохион байгуулж, галын шинжээч, гал түймрийн улсын хяналтын байцаагч, холбогдох бусад мэргэжилтнийг оролцуулан хамтран ажиллах.

2.2. Ой, хээрийн гал түймрийн шалтгаан, эзэн холбогдогчийг тогтоох, хариуцлага хүлээлгэх.

2.3. Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх зорилгоор хавар, намрын хуурайшилтын үед ногоон бүсэд нэвтрэх зорчих иргэдийн болон тээврийн

хэрэгслийн хөдөлгөөнд хяналт тавьж замуудад эргүүл, шалгалтыг Байгаль орчин, аялал жуулчлалын газартай хамтран хийж, байнгын болон хөдөлгөөнт хяналт шалгалтын цэг ажиллуулах.

Гурав: Байгаль орчин, аялал жуулчлалын газар болон, Хар ус нуурын улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаанд даалгах нь.

3.1. Ой, хээрийн гал түймэр гарах эрсдэлтэй сум, багт Ойн тухай хууль, Байгаль орчныг хамгаалах хууль, Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 106 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангуулан ажиллах.

3.2. Ойн тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай Монгол улсын хуулиар хүлээсэн үүргийн дагуу түймрийн аюултай улиралд Онцгой байдлын газартай хамтран урьдчилан сэргийлэх чиглэлээр хийх ажлын төлөвлөгөө гаргаж ухуулга сурталчилгааны ажлыг зохион байгуулах.

3.3. Дэлхийн байгаль хамгаалах сангийн Ховд аймаг дахь төлөөлөгчийн газартай хамтран ой, хээрийн түймэр гарах магадлалтай бүс нутгуудад нутгийн иргэдэд түшиглэсэн урамшуулалтай морин эргүүлийг ажиллуулах.

3.4. Тусгай хамгаалалттай газруудын захиргаанаас ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх талаар зохион байгуулж байгаа ажлыг тухай сумдын Засаг даргы Тамгын газартай уялдуулах.

3.5. Ой, хээрийн гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, тэмцэх чиглэлээр ойн анги, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийг сургаж дадлагажуулах ажлыг Онцгой байдлын газартай хамтран хэрэгжүүлэх.

Дөрөв: Цаг уур, орчны шинжилгээний газар / А.Энхзаяа /-д

4.1. Хавар, намрын хуурайшилтын улирал 2021 оны 03 дугаар сарын 20-ноос 06 дугаар сарын 10, 09 дүгээр сарын 20-ноос 11 дүгээр сарын 10-ны хугацаанд Ойн тухай хуульд заасны дагуу Цаг уур, орчны шинжилгээний төвийн сансарын хиймэл дагуулын мэдээллээр хуурайшилтын зэрэглэлийн мэдээг шуурхай авч боловсруулж Онцгой байдлын газарт хүргүүлэх.

4.2. Ойн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.16-д заасны дагуу цаг агаарын болон ой, хээрийн гал түймрийн цагийн байдлын талаарх мэдээллээр холбогдох байгууллага, ард иргэдийг хангах.

4.3. Хуурайшилтын аюултай, нэн аюултай зэрэгт хүрсэн үед цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагаанд шаардлагатай техник, тоног төхөөрөмж, бүх

5.

төрлийн сумны нөөцийг бүрдүүлж, тэдгээрийн аюулгүй ажиллагаа, хадгалалт, хамгаалалтанд хяналт тавих.

4.4. Цаг агаарын урьдчилсан мэдээг 7, 10 хоногоор гаргаж цагийн байдлыг үнэлэн урьдчилан сэргийлэх арга хэмжээг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулж ажиллах

Тав: Сумдын Засаг дарга нарт:

5.1. Албан даалгаврын хэрэгжилтийг хангуулах ажлын төлөвлөгөө боловсруулан, хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллах.

5.2. Сум орон нутгийн Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, Гал түймэр унтраах сайн дурын хэсгийн бэлтгэл, бэлэн байдлыг хангах, ой, хээрийн гал түймрийн улмаас учирч болзошгүй эрсдэлийг бууруулах зорилгоор сумын Засаг даргын захирамж гаргаж, урьдчилан сэргийлэх чиглэлээр тодорхой ажил зохион байгуулах.

5.3. Хил залгаа, сум, багийн Засаг дарга, тусгай хамгаалалттай газрын захиргаа, байгаль хамгаалагч нарыг ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх ажилд татан оролцуулж, иргэн нэг бүрт сурталчилгаа, сэрэмжлүүлгийг хүргэх.

5.4. Түймэр гарах эрсдэлтэй ой, хээр, бэлчээр, тусгай хамгаалалттай газруудад онцлон анхаарч хяналт шалгалтыг тогтмолжуулан урьдчилан сэргийлэх санамж, сэрэмжлүүлэг өгөх, аялал зугаалгыг түймрийн аюултай улиралд тодорхой хугацаагаар хязгаарлах.

5.5. Түймэр гарсан үед богино хугацаанд илрүүж орон нутгийн мэргэжлийн анги, сайн дурын хэсэг, ард иргэдийг дайчлан унтраах ажлыг шуурхай зохион байгуулах.

5.6. Ой, хээрийн гал түймэр санаатай тавьсан гэм буруутай этгээдийг олж илрүүлэхэд санаачлагатай ажиллах.

5.7. Ой, хээрийн гал түймэр гарах эрсдэл өндөртэй нутагт оршин суудаг малчид, ард иргэдэд хариуцуулан түймэр гарах магадлалтай бүс нутагт морин эргүүл, жижүүр томилж ажиллуулах.

5.8. Түймрээс хамгаалах, түймэртэй тэмцэх төлөвлөгөө боловсруулах, ой, хээрийн гал түймэр унтраах багаж хэрэгсэл, хүнсний нөөц бүрдүүлэх.

6.


5.9. Иргэдийг ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах, түймэртэй тэмцэх, амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, мал сүргээ хамгаалах арга ажиллагаанд сургаж бэлтгэх.

5.10. Ой, хээрийн болон объектын гал түймрийн тухай мэдээ, мэдээллийг тухай бүр нь мэдээлж, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, цагийн байдлын талаар Онцгой байдлын газарт шуурхай мэдээлэх.

Зургаа. Албан даалгаврын хэрэгжилтийг хангах хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээ, тайланг 2021 оны 06 дугаар сарын 05, 11 дүгээр сарын 05-ны өдрийн дотор Баруун бүсийн төв-Ховд аймгийн Онцгой байдлын газарт ирүүлэхийг байгууллагын дарга, эрхлэгч, сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

Долоо. Энэхүү албан даалгаврын хэрэгжилтэнд хяналт тавьж үүссэн цагийн байдлыг тухай бүрт, дүнг хагас, бүтэн жилээр танилцуулж ажиллахыг аймгийн Онцгой комиссын орлогч, Баруун бүсийн төв-Ховд аймгийн Онцгой байдлын газрын дарга, хурандаа Б.Алтанбадралтад үүрэг болгосугай.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД  
ОНЦГОЙ КОМИССЫН ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ